



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/112/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Булган аймаг  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14-16
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. Аудитын илрүүлэлт .....	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СӨБ	Цэцэрлэгийн өмнөх боловсрол
НББ	Нягтлан бодох бүртгэл
БСШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд

## **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

---

Цэцэрлэгийн эрхлэгч  
Ж.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны зардлыг улсын төсвөөс 454,152.5 мянга, орон нутгийн тусвөөс төсвөөс 121,103.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 99.5 хувьтай хэрэгжжээ.

Тайлант онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 396,052.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилгын их засварын ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/718 дугаар захирамж, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 275 тоот албан бичгийг үндэслэн капиталжуулж, бүртгэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Тус цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Булган сумын Засаг даргаар батлуулж ажиллажээ. Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 11 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ баталж, гүйцэтгэлийг 95 хувь тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>63,487,730.00</b>	<b>66,621,103.45</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,764,523.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	2,764,523.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	2,764,523.45
31211	Төрийн сангийн харилцах	-	2,764,523.45
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,889,000.00</b>	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,889,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,889,000.00	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>576,180,260.56</b>	<b>946,390,117.52</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>538,387,760.56</b>	<b>908,935,117.52</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	561,678,226.43	957,730,775.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62,790,181.40)	(78,405,840.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,059,248.30	46,670,348.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,003,339.12)	(34,807,544.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,745,709.20	32,012,918.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,500,152.87)	(14,413,290.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,808,700.00	11,808,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,610,449.98)	(11,660,949.94)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>37,792,500.00</b>	<b>37,455,000.00</b>
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(337,500.00)	(675,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	36,780,000.00	36,780,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>639,667,990.56</b>	<b>1,013,011,220.97</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>639,667,990.56</b>	<b>1,013,011,220.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	639,667,990.56	1,013,011,220.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	256,052,711.85	256,052,711.85
51101	Өмч: - төрийн	256,052,711.85	256,052,711.85
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(76,257,257.75)</b>	<b>297,085,972.66</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(76,257,257.75)	(76,257,257.75)
51220	Тайлант үеийн үр дүн	-	373,343,230.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	459,872,536.46	459,872,536.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>639,667,990.56</b>	<b>1,013,011,220.97</b>

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>530,828,900.00</b>	<b>981,776,749.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,322,500.00</b>	<b>396,521,049.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,322,500.00	396,521,049.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,749,900.00	396,417,549.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,572,600.00	103,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>527,506,400.00</b>	<b>585,255,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	462,963,200.00	464,152,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	464,152,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	462,963,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	250,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	64,293,200.00	121,103,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,293,200.00	121,103,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>545,246,967.76</b>	<b>608,107,558.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>545,246,967.76</b>	<b>608,107,558.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	484,047,347.09	598,139,299.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	320,504,218.36	352,128,305.55
210101	Үндсэн цалин	223,022,448.01	243,278,074.34
210102	Нэмэгдэл	61,705,909.20	85,513,240.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,344,998.80	-
210104	Урамшуулал	25,430,862.35	23,336,991.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,429,634.97	53,892,733.00
210201	Тэтгэврийн даатгал	27,577,875.87	36,646,963.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,060,859.58	4,312,142.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,448,687.57	3,449,713.85
210204	Ажилгүйдлийн даатгал	576,564.82	1,005,928.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,765,647.13	8,477,984.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,293,200.00	97,432,954.00
210301	Гэрэл, цахилгаан	1,965,313.57	4,519,837.00
210302	Түлш, халаалт	57,158,050.43	84,362,002.00
210303	Цэвэр, бохир ус	4,169,836.00	8,551,115.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,267,392.00	5,191,336.00
210401	Бичиг хэрэг	451,900.00	-
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	392,617.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,722,600.00	121,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	671,400.00	-
210408	Бараа материал акталсны зардал	908,875.00	5,069,836.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,793,826.00	47,308,114.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,000.00	-
210502	Хоол, хүнс	14,774,826.00	47,308,114.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,241,150.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	8,241,150.00	1,000,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	99,400.00	-
210702	Дотоод албан томилолт	99,400.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	284,450.00	521,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	284,450.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	521,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,134,075.76	40,664,856.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	372,720.00	7,267,725.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	878,848.00	3,502,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,882,507.76	29,894,731.73
210904	Найдваргүй авлагын алдагдал		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	61,199,620.67	9,968,259.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	699,850.00	9,822,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	699,850.00	9,822,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	60,499,770.67	146,159.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,499,770.67	146,159.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(14,418,067.76)</b>	<b>373,669,190.72</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	0.04	325,960.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.04	325,960.31
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(0.04)	(325,960.31)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(14,418,067.80)</b>	<b>373,343,230.41</b>

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>527,506,400.00</b>	<b>585,255,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>527,506,400.00</b>	<b>585,255,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>462,963,200.00</b>	<b>464,152,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	464,152,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	462,963,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>250,000.00</b>	<b>-</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>64,293,200.00</b>	<b>121,103,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,293,200.00	121,103,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>523,998,709.00</b>	<b>580,966,176.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>523,998,709.00</b>	<b>580,966,176.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>462,799,088.33</b>	<b>570,997,917.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>320,504,218.36</b>	<b>352,128,305.55</b>
210101	Үндсэн цалин	223,022,448.01	243,278,074.34
210102	Нэмэгдэл	61,705,909.20	85,513,240.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,344,998.80	-
210104	Урамшуулал	25,430,862.35	23,336,991.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,429,634.97</b>	<b>53,892,733.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,577,875.87	36,646,963.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,060,859.58	4,312,142.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,448,687.57	3,449,713.85
210204	Ажилгүйдлийн даатгал	576,564.82	1,005,928.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,765,647.13	8,477,984.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,293,200.00</b>	<b>97,432,954.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,965,313.57	4,519,837.00
210302	Түлш, халаалт	57,158,050.43	84,362,002.00
210303	Цэвэр, бохир ус	4,169,836.00	8,551,115.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,924,017.00</b>	<b>121,500.00</b>
210401	Бичиг хэрэг	483,700.00	-
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	392,617.00	-
210404	Ном, хэвлэл	58,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	121,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,119,500.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,193,360.00</b>	<b>47,912,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,400.00	-

210502	Хоол, хүнс	15,499,960.00	47,912,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,628,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,512,209.00</b>	<b>1,000,000.00</b>
210602	Тавилга	512,209.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>99,400.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	99,400.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,088,800.00</b>	<b>521,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,088,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	521,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,754,249.00</b>	<b>17,988,725.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,117,561.00	13,428,725.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,636,688.00	4,560,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,199,620.67</b>	<b>9,968,259.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>699,850.00</b>	<b>9,822,100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	699,850.00	9,822,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>60,499,770.67</b>	<b>146,159.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,499,770.67	146,159.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,507,691.00</b>	<b>4,289,523.45</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,507,691.00</b>	<b>1,525,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,507,691.00</b>	<b>1,525,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,507,691.00</b>	<b>1,525,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	519,900.00	441,000.00
223001	Бусад хөрөнгө	2,987,791.00	1,084,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(3,507,691.00)</b>	<b>(1,525,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(0.00)	2,764,523.45
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	2,764,523.45

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,052,711.85	459,872,536.46	(61,839,189.95)	654,086,058.36
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>256,052,711.85</b>	<b>459,872,536.46</b>	<b>(61,839,189.95)</b>	<b>654,086,058.36</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,418,067.80)	(14,418,067.80)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,052,711.85	459,872,536.46	(76,257,257.75)	639,667,990.56
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	256,052,711.85	459,872,536.46	(76,257,257.75)	639,667,990.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>256,052,711.85</b>	<b>459,872,536.46</b>	<b>(76,257,257.75)</b>	<b>639,667,990.56</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	373,343,230.41	373,343,230.41
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,052,711.85	459,872,536.46	297,085,972.66	1,013,011,220.97

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>527,256,400.00</b>	<b>466,506,629.33</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	527,256,400.00	466,506,629.33
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	526,556,400.00	465,806,779.33
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>361,854,300.00</b>	<b>320,504,218.36</b>
210101	Үндсэн цалин	238,364,400.00	223,022,448.01
210102	Нэмэгдэл	73,303,600.00	61,705,909.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	10,344,998.80
210104	Урамшуулал	38,186,300.00	25,430,862.35
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,145,300.00</b>	<b>39,429,634.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,631,100.00	27,577,875.87
210202	Тэтгэмжийн даатгал	3,660,600.00	3,060,859.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,870,800.00	2,448,687.57
210204	Ажилгүйдлийн даатгал	725,700.00	576,564.82
210205	Эрүүл мэндийн даатгал	7,257,100.00	576,564.13
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,293,200.00</b>	<b>63,293,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	200,000.00	196,531.57
210302	Түлш, халаалт	57,093,200.00	57,158,050.43
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,169,836.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,924,000.00</b>	<b>4,424,017.00</b>
210401	Бичиг хэрэг	500,000.00	483,700.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	120,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	530,000.00	392,617.00
210404	Ном, хэвлэл	74,500.00	58,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,119,500.00	2,119,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	<b>Нормативт зардал</b>	<b>34,376,600.00</b>	<b>24,193,360.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,400.00	65,400.00
210502	Хоол, хүнс	25,681,700.00	15,499,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,629,500.00	8,628,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,500,000.00</b>	<b>4,500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга	3,500,000.00	3,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	<b>Томилот, зочны зардал</b>	<b>99,400.00</b>	<b>99,400.00</b>

210702	Дотоод албан томилолт	99,400.00	99,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,088,800.00</b>	<b>5,088,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,088,800.00	5,088,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,274,800.00</b>	<b>4,274,149.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,118,200.00	1,117,561.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,156,600.00	3,156,588.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>700,000.00</b>	<b>699,850.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>699,850.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	699,850.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	527,256,400.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	462,963,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	462,963,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	<b>64,293,200.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	-	64,293,200.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>2,764,523.45</b>

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

#### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Булган сумын 1 дүгээр цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд “Хүүхдийн хөгжил, төлөвшил, ахицыг дэмжих, багш ажилтныг ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлэх гэсэн зорилгын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлж ажиллажээ. Үүнд:

1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, цахим хичээлийн сан болон дасгал даалгаврын сан бүрдүүлэн ажиллах
2. Багш ажилтан ажлын байрандаа тасралтгүй хөгжих, тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, эерэг уур амьсгал бүрдүүлэх, мэдээлэл харилцаа холбоо, технологийн ур чадварыг хөгжүүлэх
3. Сургалтын хөтөлбөрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах
4. Хоол хүнсний эрүүл ахуйн байдлыг хангаж, хүртээмж чанарыг сайжруулах
5. Цэцэрлэгийн үйл ажиллагаа, хүүхдийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан хөгжлийг дэмжихэд эцэг эх асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг түншлэлийг идэвхжүүлэх
6. Тойргийн болон тойргийн бус 5 настай хүүхдийг сургалтын аль нэг хэлбэрт хамруулж, сургуульд бэлтгэх

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль, СӨБ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, 107 БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1649 дугаар албан бичгээр ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөгүй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Булган сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгө өмнөх оноос 373,343.2 мянган төгрөгөөр буюу 58.4 хувиар өссөн.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	2,764.5	2,764.5
Авлага	2,889.0	0.0	(2,889.0)
Бараа материал	60,598.7	63,856.6	3,257.9
Үндсэн хөрөнгө	576,180.3	946,390.1	370,209.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>639,668.0</b>	<b>1,013,011.2</b>	<b>373,343.2</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	639,668.0	1,013,011.2	373,343.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>639,668.0</b>	<b>1,013,011.2</b>	<b>373,343.2</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Өмнөх онд “Битачи” ХХК-тай гэрээ байгуулсан боловч хил хаалттай шалтгааны улмаас нийлүүлэгдээгүй хүүхдийн тоглоомын үнэ 2,889.0 мянган төгрөгийн авлагад тус компаниас 2,488.0 мянган төгрөгийн ширээ сандал, 401.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом авч авлагыг бүрэн барагдуулжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 63,856,6 мянган төгрөг болж 3,257.9 мянган төгрөгөөр өсөхөд 3,150.0 мянган төгрөгийн 3 ээлжийн хүүхдийн ор, хөнжлийн даавуу худалдан авч, бусад хангамжийн материалд бүртгэсэн нь нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 946,390.1 мянган төгрөг болж 370,29.8 мянган төгрөгөөр өссөн нь 396,052.5 мянган төгрөгийн барилгын их засварын ажлыг капиталжуулж, бүртгэсэнтэй холбоотой байна. Тайлант онд 1,525.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хүүхдийн тоглоомын авлагад 2,488.0 мянган төгрөгийн ширээ сандал авч, 1,499.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,013,011.2 мянган төгрөг болж 373,343.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 450,947.8 мянган төгрөгөөр буюу 85 хувиар өсөхөд орон нутгаас санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт 56,810.0 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 394,667.6 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 62,860.6 мянган төгрөгөөр өсөхөд бараа, ажил үйлчилгээний зардал 114,092.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, урсгал шилжүүлгийн зардал 51,231.3 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын 1 дүгээр цэцэрлэг 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 688,314.5 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 292,452.9 мянган төгрөгөөр бууруулж 395,861.6 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнээс шалтгаалжээ. Тухайлбал: цалингийн нэмэгдэл, урамшууллыг Тайлант жилд анхны батлагдсан төсвийг 2 удаа тодотгож, 1,254,986.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 464,152.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 121,103.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 582,491.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2,764.5 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 582,491.2 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 4,289.5 мянган төгрөгөөр дутуу, бусад урсгал зардлыг 146.2 мянга, хөрөнгийн зардлыг 1,525.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Хөтөлбөр СӨБ- 78801	585,255.7	582,491.2	2,764.5	99.53
	Арга хэмжээ 80111	98,579.0	98,433.1	145.9	99.85
	Арга хэмжээ 80112	22,524.2	22,524.1	0.1	100
	81605	1300.0	1,228.0	72.0	94.46
	81807	47,914.5	47,912.7	1.8	100
	81816	1,416.5	1,416.5	0.0	100
	81823	1,300.0	1,300.0	0.0	100
	81834	344,823.8	342,377.5	2,446.3	98.95
	81835	67,397.7	67,153.2	244.5	99.63

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Бүжингоо нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 545,247.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,452.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. 2022 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 608,107.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,081.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Энэ хуулийн хүрээнд батлагдсан төсөв 2,764.5 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь урсгал зардал 4,289.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн ч хөрөнгө худалдан авахад 1,525.0 мянган төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн. Тайлант онд үндсэн цалин 32,377.6 мянган төгрөгөөр хэмнэгдэж, нэмэгдэл, урамшуулал 29,687.4 мянган төгрөгөөр хэтэрсэн нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад хамаарах 20,886.5 мянган төгрөгийн бараа худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 6.1.5, 6.2.4, 6.3.7-д заасан тайлан, мэдээллийг хугацаа хоцроосон байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газар түүвэрт хамруулсан бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 22,114.5. мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 1,228.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 20,886.5 төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

#### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **5.2 Албан шаардлага**

Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Т.Ганчимэг, Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга П.Бямбасүрэнтэй сургууль, цэцэрлэгийн багш ажилтныг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах тухай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, үр дүн тодорхой бус байна.

Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/238, А/340 дүгээр тушаалын 3.1, 3.2, БШУС-ын 2022 оны 07 дугаар сарын 22-ны А/259 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулах заавар”-ын 2.3, 2.5, 2.7.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3 Зөвлөмж

#### Илрүүлэлт:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, 6.3.7, 6.4. дэх заалттай нийцэхгүй байна. Энэ нь хэрэглэгчдэд үнэн зөв мэдээллийг хугацаанд нь хүргэхгүй байх үр дагавартай.

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Залруулсан		Залруулаагүй			Тоо
					Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цэцэрлэгийн багш, ажилтныг эрүүл мэндийн нэмэлт үзлэг оношилгоонд хамруулах ажлыг холбогдох заавар, журмын дагуу зохион байгуулаагүй	1	1,228.0	-	-	1	1,228.0	-	-	-	-	-	-
Дүн	1	1,228.0			1	1,228.0						

